# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр | Дугаар А/128 | Булган сум

Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аян
зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.4, 9.3.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV Хуралдааны XIV/01 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд зарласугай.

2."Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр, ажлын төлөвлөгөөг 2 дугаар, зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус батласугай.

3.Аяныг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр), Цагдаагийн газар (Г.Ганбаатар, Цагдаагийн хурандаа), Эрүүл мэндийн газар (С.Нарантуяа), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Сум, орон нутагтаа аяныг зохион байгуулах ажлын хэсэг томилж, нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулж, ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

5.Аяныг зохион байгуулахад шаардлагатай 33 951 000 (гучин гурван сая есөн зуун тавин нэгэн мянга) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

6."Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяны хүрээнд зохион байгуулсан ажлын дүнг 2022 оны 06 дугаар сарын 15, 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын



6323010083

зөвлөлийн хуралд тус бүр танилцуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 06-ны өдрийн А/128 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

"ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН" АЯНЫ УДИРДАМЖ

## Нэг. Аяны зорилго

"Байгаль орчныг хамгаалах тухай" хууль, "Хог хаягдлын тухай" хууль, аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, хог хаягдлыг багасгах, орчны бохирдол доройтлыг бууруулах ажлыг зохион байгуулж, хоггүй цэвэр сайхан орчныг бүрдүүлэхэд оршино.

## Хоёр. Хамрах хүрээ

Аймгийн хэмжээнд сум, баг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага

## Гурав. Хэрэгжүүлэх хугацаа

Аймгийн хэмжээнд "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг дуустал зохион байгуулна.

## Дөрөв. Аяны үйл ажиллагааны чиглэл

Аяныг удирдлага зохион байгуулалт,хамтын ажиллагаа, сургалт сурталчилгаа зохион байгуулах, хог хаягдлыг цэвэрлэн орчны доройтлыг бууруулж, эрүүл ахуйг сайжруулах, хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх гэсэн чиглэлээр зохион байгуулна.

**Нэгдүгээр чиглэл: Удирлага зохион байгуулалт, хамтын ажиллагаа**

1."Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяны захирамж, төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх

2. Хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөөг боловсруулж, батлуулах

3. "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяны төлөвлөгөөний дагуу бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах

4. БОАЖ-ын Сайдын албан даалгаврыг сумын Засаг дарга, ААНБ-ын дарга нарт хүргүүлэх

5. Хог хаягдлын талаар хийсэн ажлын тайланг сумдаас хагас, бүтэн жилээр авч нэгтгэх.

6. Сумдыг зохион байгуулсан ажлаар нь дүгнэн байр эзлүүлэх

**Хоёрдугаар чиглэл: Мэдээлэл, сургалт сурталчилгаа зохион байгуулах**

1. Аяныг сурталчлах олон нийтийг хамруулсан өдөрлөг, сурталчилгааны ажил зохион байгуулах

2. Хог хаягдлын тухай хууль, хог хаягдлыг багасгах, ангилан ялгах, эргүүлэн ашиглах, гялгар уутны хэрэглээнээс татгалзах талаар сургалт зохион байгуулж, сурталчилгаа хийх

3. Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, тогтсон цэгт хаях, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, стандартын шаардлага

хангасан ариун цэврийн байгууламжтай болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтэд тогтмол сурталчлах

4. Олон нийтийн цахим сүлжээгээр аяныг сурталчилан зохион байгуулж байгаа ажлын мэдээллийг олон нийтэд хүргэх

5. Сумдад хүүхэд, залуучуудад экологийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байх

**Гуравдугаар чиглэл: Хог хаягдлыг цэвэрлэн орчны бохирдлыг бууруулах, эрүүл ахуйг сайжруулах үйл ажиллагаа**

1. Төв суурин газарт нийтийн эзэмшлийн талбай, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах

2. Сум, багуудад өвөлжөө, хаваржаа, бэлчээр, гол горхи, нуур цөөрмийн хог хаягдал, үхсэн малын сэг зэмийг цэвэрлэх

3. Улсын болон орон нутгийн чанартай авто зам, уул даваа, овоо тахилгын хог хаягдлыг цэвэрлэх

4. Төвлөрсөн хог хаягдлын цэгийг хумих, цэгцлэх, булшлах, зэрэглэл ахиулах арга хэмжээ авах, эзэнгүй хог хаягдал, хууль бус хогийн цэгүүдийг цэвэрлэх, дарж булах

5. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, үүсгэгч нь хариуцах, санхүүжилт урамшууллын шинэ систем нэвтрүүлэх

6. Аймгийн баяр наадмын өмнө, хойно нийтийг хамарсан цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах

7. Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүд, аливаа арга хэмжээ зохион байгуулахдаа талбайгаас 500 метрээс доошгүй зайд автомашины зогсоолын талбай, хог хаягдлын цэг, байгаль орчинд ээлтэй ариун цэврийн байгууламжийг байрлуулж тэмдэгжүүлэх,үүссэн хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажлыг зохион байгуулах

8. Улсын болон орон нутгийн чанартай автозамын дагуух үйлчилгээний цэгүүдийн нүхэн жорлонг буулгаж, хөрсийг нөхөн сэргээх арга хэмжээ авах

**Дөрөвдүгээр чиглэл: Хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх**

1. Хог хаягдалтай холбоотой зөрчлийг шийдвэрлэх ажлыг иргэд байгууллагуудад ойлгуулан таниулах ажлыг сум бүр зохион байгуулах /Сум, багийн Засаг дарга, Цагдаа, Байгаль орчны хяналтын улсын байцаагч хариуцан гүйцэтгэх/

2. Олон нийтийн байцаагч ажиллуулж, ил задгай, зориулалтын бус газар хог хаягдал хаях, шатаах зөрчлүүдэд тогтмол хяналт тавих

3. Хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх,хуулийг хэрэгжүүлэх, ариун цэврийн байгууламжуудыг стандартад нийцүүлэх, холбогдох хууль тогтоож, стандартын хэрэгжилтэд тогтмол хяналт шалгалт зохион байгуулах зорилготойгоор сум, багийн Засаг дарга, цагдаа, байгаль орчны хяналтын байцаагчдын зөрчил гаргагчдад оногдуулах торгууль, шийтгэврийн ажлыг эрчимжүүлэх,

**Тав. "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг дүгнэх**

1.Сумдыг аяны хүрээнд зохион байгуулсан ажлаар нь дүгнэн байр эзлүүлнэ.

2.Аяны хүрээнд зохион байгуулсан ажлыг дүгнэхдээ зохион байгуулсан ажлын үр дүн, чанар, хог хаягдлыг ангилан ялгах, цэвэрлэх, багасгах, орчны бохирдлыг бууруулах ажилд шинэлэг санаа гаргаж хэрэгжүүлсэн ажил, Байгаль орчин, аялал жуулчлалын

сайдын албан даалгавруудыг цаг тухай бүр хэрэгжүүлэн хийсэн ажлын мэдээг цаг хугацаанд нь ирүүлсэн, аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэд, аялал жуулчлалын аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулсан байдал зэргийг харгалзан үзнэ.

Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

Аймгийн Засаг даргын 2023 оны
02 дугаар сарын 06-ны өдрийн А/128 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

# “ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН” АЯНЫ ХҮРЭЭНД ХОГ ХАЯГДЛЫГ БАГАСГАХ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ/2023 ОН/

| № | Авч хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний төлөвлөгөө | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч | Санхүүжих эх үүсвэр (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. Удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагааны чиглэлээр | | | | | | | | |
| 1.1 | “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх | 1.1.1.Хог хаягдлын талаар 2023 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган аймгийн Засаг даргаар батлуулах | III/06 | БОАЖГ | ХОХБТХ | - | Хугацаанд нь боловсруулж батлуулна. | Аяны төлөвлөгөөг |
| | | 1.1.2. БОАЖ-ын Сайдын албан даалгаврыг сумын Засаг дарга, ААНБ-ын дарга нарт хүргүүлэх | III/06 | БОАЖГ | СЗДТГ | - | Хугацаанд нь хүргүүлсэн байна. | Албан даалгаврын хэрэгжилтийг хугацаанд нь зохион байгуулна. |
| | | 1.1.3. Сумд “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх | III/07-XI/06 | СЗДТГ | Багийн Засаг дарга, иргэд, ААНБ | - | Нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ээнжүүлсэн байна. | Аяныг чанартай сайн зохион байгуулсан байна. |
| 1.2 | Хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөөг боловсруулах | 1.2.1.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-д танилцуулан батлуулах | I-II улирал | БОАЖГ | Булган сумын ТҮА | - | Аймгийн ИТХ-ын Хуралдаанаар батлагдсан байна | Хог хаягдлын асуудлыг шат дараатай шийдвэрлэх төлөвлөгөөтэй болно. |
| 1.3 | “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяны хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах | 1.3.1.Хаврын цэвэрлэгээний ажлыг 2 сарын хугацаатай, баяр наадмын үеийн цэвэрлэгээг 2 удаа, намрын цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулах. | IV/05-VI/05, VII/04-VII/15 VIII/10-15 IX/26-30 | БОАЖГ | СЗДТГ | ОНТ | Цаг хугацаанд нь чанартай сайн зохион байгуулна | Аймгийн хэмжээнд хатуу хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажил хийгдсэн байна.. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4 | Хог хаягдлын хуулийн дагуу үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах,ажлыг зохион байгуулах | 1.4.1.Компаниудын гэрээт борлуулагч нартай сав баглаа боодлоо эргүүлэн татах гэрээ байгуулах | III/15-IV/15 | СЗДТГ | ААНБ | Үйл ажиллагаа гаар | Бүх гэрээт борлуулагч нартай гэрээ байгуулан ажиллана. | Хог хаягдлын хуулийн хэрэгжилт хангагдаж, хог хаягдлын цэгт хүргэх хог хаягдлын хэмжээ багасна. |
| | | 1.4.2.Хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулдаг ААНБ, иргэдийг нийгмийн хариуцлагын хүрээнд худалдан борлуулсан бүтээгдэхүүний сав баглаа боодлыг буцаан авах талаар тодорхой ажил зохион байгуулах | I- IV улирал | СЗДТГ | ААНБ,иргэн | Үйл ажиллагаа гаар | Сумын хэмжээнп үйл ажиллагаа явуулдаг иргэн, ААНБ-ыг бүрэн хамруулна. | |
| 1.5 | Шатахуун түгээх станцуудтай гэрээ байгуулан ажиллах | 1.5.1.Шатахуун түгээх станцуудын дэргэд боловсон жорлон, хог хаягдал ангилан хийдэг хогийн сав байрлуулах ажлыг зохион байгуулах | I-II улирал | СЗДТГ | ААНБ, ШТС | ААНБ-ын хөрөнгө | ШТС-уудыг бүрэн хамруулсан байна. | Зорчин явагчид хог хаягдлаа хийх цэгтэй болж, эзэнгүй хог хаягдал багасна. |
| | | 1.5.2.Хогийн савны хог хаягдлыг ачиж зайлуулах ажлыг зохион байгуулах | I- IV улирал | ШТС | СЗДТГ | ААНБ-ын хөрөнгө | Гэрээ байгуулж, сад 1удаа ачиж, бүртгэл хөтөлсөн байна. | Сумын ЗДТГ-тай гэрээ байгуулан хог хаягдлыг ачиж тээвэрлэнэ. |
| 1.6 | Орхон аймагтай гэрээ байгуулан ажиллах | 1.6.1.Хил залгаа сумдын нутаг дэвсгэрийн хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажлыг хамтран зохион байгуулах /Орхон, Бугат, Хангал, Сэлэнгэ/ | V-VI сар | Булган, Орхон аймгийн ЗДТГ, БОАЖГ | СЗДТГ | ОНТ | Жилд 32 удаа зохион байгуулсан байна. | Хил залгаа нутаг дэвсгэрийн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулна. |
| 1.7. | Хог хаягдлын талаар хийсэн ажлын тайланг нэгтгэх, дүгнэх | 1.7.1.Сумдыг зохион байгуулсан ажлаар нь дүгнэн байр эзлүүлнэ. | X/15 | БОАЖГ | СЗДТГ | Үйл ажиллагаа гаар | Шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ. | Сумын Засаг даргын ажлын гол үзүүлэлт болгон дүгнэж, байр эзлүүлнэ. |
| | | 1.7.2.Хог хаягдлын талаар хийсэн ажлын тайланг сумдаас хагас, бүтэн жилээр авч нэгтгэх | VI/15 X/15 | БОАЖГ | СЗДТГ, ААНБ | Үйл ажиллагаа гаар | Хугацаанд нь хүргүүлнэ. | Жилийн ажлын дүнг дүгнэнэ. |
| **2.Мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах талаар** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | Аймгийн хэмжээнд “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аян, хог хаягдлыг багасгах, цэвэрлэх ажлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | 2.1.1.Олон нийтийн ТВ-ээр “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аян, ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, тогтсон цэгт хаях, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтэд тогтмол сурталчлах | Аяны хугацаанд | БОАЖГ | СЗДТГ | ОНТ | Тухай бүр | Зохион байгуулж байгаа үйл ажиллагааг улсын хэмжээнд сурталчилна. |
| | | 2.1.2.Орон нутгийн ТВ-ээр хог хаягдлыг багасгах, ангилан ялгах талаар болон “Аяллын хоггүй аймаг” уриалгыг сурталчлах | VI/01-IX/01 | БОАЖГ | СЗДТГ, ТҮА, Сайхан Монгол ТВ | ОНТ | Сард 2-оос доошгүй Сурталчилгаа хийсэн иргэдийн тоо | Иргэд олон нийтэд мэдээлэл түгээнэ. |
| | | 2.1.3.Аялал жуулчлалын ААНБ-ууд амрагч, жуулчдад хог хаягдлыг багасгах талаар сурталчилгаа хийх | VI/01-IX/01 | ААНБ | БОАЖГ, СЗДТГ | Үйл ажиллагаа гаар | Сурталчилгаа хийсэн иргэдийн тоо | Амрагч, жуулчдад мэдээлэл түгээнэ. |
| 2.2 | Цахим орчин, олон нутгийн сүлжээгээр сурталчлан таниулах | 2.2.1.Хог хаягдлыг ангилан ялгах, эргүүлэн ашиглах талаарх шторк, зурган мэдээлэл, санамжуудийг цахим орчноор сурталчлах | Аяны хугацаанд | БОАЖГ | СЗДТГ, ААНБ | Үйл ажиллагаа гаар | Сард 2-оос доошгүй Сурталчилгаа хийсэн иргэдийн тоо | Иргэд хог хаягдлыг багасгах, ангилан ялгах талаар тодорхой мэдлэгтэй болно. |
| | | 2.2.2.Хог хаягдлыг багасгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлыг олон нийтэд түгээх, сурталчилан танилцуулах | Аяны хугацаанд | АЗДТГ-ын ХМОНХА, БОАЖГ | СЗДТГ, ААНБ | Үйл ажиллагаа гаар | Хагас, бүтэн жилээр 2 удаа Сурталчилгаа хийсэн иргэдийн тоо | Иргэд мэдээллээр хангагдана. |
| 2.3 | Сургалт зохион байгуулах | 2.3.1. Каритас Чех Репаблик, Монголын тогтвортой хөгжлийн гүүр, Монголын байгаль орчин, аюулгүй байдлыг төвөөс хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах” төсөлтэй хамтран сургалт зохион байгуулах | I-IV улиралд | БОАЖГ | Каритас Чех Репаблик, Монголын тогтвортой хөгжлийн гүүр, Монголын байгаль орчин, аюулгүй байдлыг төв | Үйл ажиллагаа гаар | 2 удаа | Иргэд мэдээллээр хангагдана. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2.3.2.Булган суманд зохион байгуулах “Цэгцэльe-Цэмцийе” аяны хүрээнд ИНБ-тай хамтран 6 багт хог хаягдлыг ангилан ялгах талаар сургалт мэдээлэл хийх | III/15-IV/25 | СЗДТГ, БОАЖГ, Төсөл | ТҮА | Үйл ажиллага агаар | Баг бүрт 20-оос доошгүй хүнийг хамруулсан байна. | Иргэд хог хаягдлыг багасгах, ангилан ялгах талаар тодорхой мэдлэгтэй болно. |
| | | 2.3.3.Сумдад сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах /Тамгын газрын ажилтнууд, ААНБ-ын дарга нар, багийн Засаг дарга, иргэдийг хамруулна/ | V/01-VII/01 | БОАЖГ | СЗДТГ | ОНТ | 16 сум,1 тосгонд | Сумын багийн Засаг дарга, иргэдэд байгаль орчныг хамгаалах, хог хаягдлыг багасгах талаар сургалт зохион байгуулж, аяны үйл ажиллагаар сурталчилна. |
| **3.Хог хаягдлыг цэвэрлэн орчны доройтлыг бууруулж, эрүүл ахуйг сайжруулах үйл ажиллагаа** | | | | | | | | |
| 3.1 | “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” ‘ аяныг зохион байгуулах | 3.1.1.Сумын Засаг дарга, багийн Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хогийн савны ашиглалтыг сайжруулах заалтыг тусган хэрэгжүүлэх /Булган сум/ | I-VI сар | БОАЖГ | Сумын Засаг дарга, багийн Засаг дарга | Үйл ажиллага агаар | Ангилан ялгадаг айл өрхийн тоо | Хогийн савны ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулна. |
| | | 3.1.2.Булган сумын багуудын хооронд хог хаягдлыг хамгийн сайн ангилан ялгасан “Жишиг гудамж” шалгаруулах уралдаан зарлах | II-V сар | СЗДТГ | Багийн Засаг дарга, ААНБ, иргэд | Сумын төсөв | Уралдааныг зарлаж дүгнэсэн байна. | Хогийн савны ашиглалтыг сайжирч, иргэд хог хаягдлаа ангилан ялгаж хэвшинэ. |
| | | 3.1.3.Булган сум ангилсан хогийг ачих хуваарь гарган, ТҮА тусд нь тээвэрлэх ажлыг зохион байгуулах | Жилдээ | СЗДТГ, ТҮА | Иргэд,ААН Б | Үйл ажиллага агаар | Хуваарь гаргаж, сард 1 удаа тээвэрлэнэ. | Дахин ашиглагдах хог хаягдлын нөөц бүрдэнэ. |
| | | 3.1.4.ТҮА-д олгосон хог хаягдал прeслэгчийг ашиглалтад оруулах | Сард нэг удаа прeслэх | ТҮА | СЗДТГ | Үйл ажиллага агаар | Прeслэгчийг ажилуулж, хог хаягдлыг прeслэнэ. | Дахин ашиглагдах хог хаягдлын нөөцтэй болж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлдэц хийх боломж бүрдэнэ. |
| | | 3.1.5.Хог ангилан ялгах цехийн түрээслэгчтэй үйл ажиллагаар өргөжүүлэх, ангилсан хог хаягдлыг хүлээн авах ажлыг сайжруулах гэрээ байгуулж, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх | II/14-22 | БОАЖГ | Булган сумын ЗДТГ, ТҮА | Үйл ажиллага агаар | Дахин ашигласан, болосруулсан бүтээгдхүүний хэмжээ нэр төрөл нэмэгдсэн байна. | Ангилсан хогийг бэлдэц болон эцсийн бүтээгдэхүүн болгох үйл ажиллагаа сайжирна. |
| | | 3.1.6.Булган сумын нийтийн эзэмшлийн талбай, орон сууцны | IV/05-VI/05 | СЗДГ, ТҮА | ААНБ | Үйл ажиллага агаар | Хогийн савны тоо | Хогийн савны насжилт сайжирч, өнгө үзэмж нэмэгдэнэ. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | гаднах хогийн савыг засварлаж, өнгө үзэмжийг сайжруулах | | | | | | |
| | | 3.1.7.Сумын төвийн хогийн савыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах | I-II улирал | СЗДТГ | ААНБ | Сумын төсөв, ААНБ-ын хөрөнгө | Хогийн савны тоо | Стандартын шаардлага хангасан хогийн савтай болж, эзэнгүй хог хаягдал багасна. |
| | | 3.1.8.Сумд хог хаягдлыг ангилан ялгах ажлыг эрчимжүүлж, ангилсан хог хаягдлыг хүлээн авах цэгүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх | Жилдээ | СЗДТГ | ААНБ, иргэд | Үйл ажиллага агаар | 2 догч түүхий эд авах цэгийн үйл ажиллагааг жигдрүүлнэ. | Хог хаягдлыг ангилан ялгах боломж бүрдэж, байгальд хаягдах хог хаягдлын хэмжээ багасна. |
| | | 3.1.9.Ангилсан хог хаягдлыг тушаах газартай гэрээ байгуулан тогтсон хугацаанд ачиж тээвэрлэх ажлыг зохион байгуулах | Жилдээ | СЗДТГ | ААНБ, иргэд | Үйл ажиллага агаар | Ангилж, тушаасан хог хаягдлын хэмжээ | Ангилсан хог хаягдлыг дахин ашиглах боломж бүрдэнэ. |
| | | 3.1.10.Хаврын бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулан айл өрх, ААНБ өөрийн эзэмшил газрын хог хаягдлыг цэвэрлэн зайлуулж, хашаа, байрныхаа өнгө үзэмжийг сайжруулах | IV/05-VI/05 | БОАЖГ | СЗДТГ, ААНБ | ОНТ | Чанартай сайн зохион байгуулж, тайланд тусгана. | Хатуу хог хаягдлыг цэвэрлэн зайлуулж, орчны бохирдол багасна. |
| | | 3.1.11.Гол горхи, рашаан ус, нуур цөөрөм, уст цэгүүдийн орчны хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах | IV/05-V/25 | СЗДТГ, ААНБ | Иргэд | ОНТ | | Уст цэгүүдийн бохирдлыг багасгаж, бохирдлоос урьдчилан сэргийлнэ |
| | | 3.1.12.Хог хаягдлыг багасгах, ангилан ялгах, дахин ашиглах талаар шинэ санаачлага, гарган хэрэгжүүлэх | IV/05-VI/05 | СЗДТГ | ААНБ, иргэд | Үйл ажиллага а, сумын төсөв | | Олон нийтэд түгээн дэлгэрүүлэхүйц шинэ санаа санаачлага бүхий 2-оос доошгүй ажил зохион байгуулсан байна. |
| | | 3.1.13.Хөдөөний малчин айл өрхийг нүүхдээ буйраа цэвэрлэдэг уламжлалт зан заншлыг сэргээж, зун, намрын нутагласан газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх тодорхой ажил зохион байгуулсан байх /Буйраа цэвэрлэх талаар гэрээ хэлцэл байгуулж ажиллах/ | Тухай бүр | СЗДТГ, Багийн Засаг дарга | Малчин өрх | Үйл ажиллага агаар | Гэрээ, хэлцэл байгуулсан өрхийн тоо | Эзэнгүй хог хаягдал багсаж, орчны бохирдол буурна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2 | Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах | 3.2.1.Сумдад хатуу хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилох | IV/05-10 | СЗДТГ | ААНБ | Үйл ажиллагаа агаар | Сумын Засаг даргын захирамжаар томилсон байна. | Ажлыг ээнжүүлж, чанартай хийж гүйцэтгэнэ. |
| | | 3.2.2.Айл өрх, ААНБ-ын цэвэрлэсэн хог хаягдлыг нэгдсэн журмаар ачиж хогийн төвлөрсөн цэгт хаях | IV/05-V/25 IX/20-X/01 | СЗДТГ, ААНБ | Иргэд | ОНТ | Чанартай сайн зохион байгуулж, тайланд тусгасан байна. | |
| | | 3.2.3.Сэг зэмийг цэвэрлэж, устгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах | IV/05-V/25 | МЭГ, СЗДТГ | ААНБ, Иргэд | ОНТ | | |
| | | 3.2.4.Төв суурин газрын ойролцоох овоо тахилгын орчныг цэвэрлэж, тохижуулах | IV/05-V/25 | СЗДТГ | ААНБ, Иргэд | ОНТ | | |
| | | 3.2.5.Улсын болон орон нутгийн чанартай зам болон даваан дээрх овоо тахилгын орчны цэвэрлэх | IV/15-V/25 IX/25-X/01 | СЗДТГ | ААНБ, Иргэд | ОНТ | | |
| | | 3.2.6.Хөдөөний багуудын айл өрхийн өвөлжөө, хаваржааны хог хаягдлыг цэвэрлэх | IV/15-V/25 | Багийн Засаг дарга | Айл өрх | Өөрийн хөрөнгө | | |
| | | 3.2.7.“Цэвэрхэн наадацгаая” уриан дор үндэсний баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах | VI/25-VII/05, VII/15-VII/25 | СЗДТГ | ТҮА, ААНБ, иргэд | Үйл ажиллагаа агаар | | |
| | | 3.2.8.Үерийн далан, суваг шуудууг цэвэрлэх | VI/10-12 | СЗДТГ | ААНБ | ОНТ | | |
| | | 3.2.9.Сум, байгууллага бүр хийсэн ажлын тайлан мэдээг тоо баримт, фото зургаар баримтжуулан БОАЖГ-т ирүүлэх | VI/05-10 XI/15-20 | БОАЖГ | Сумын ЗДТГ | Үйл ажиллагаа агаар | Үнэн зөв гаргаж, статистик мэдээллийн хамт ирүүлнэ. | |
| 3.3 | Аяллын хоггүй аймаг уриалга гарган хог хаягдлыг багасгах ажлыг зохион байгуулах | 3.3.1. Сум бүр “Аяллын хоггүй аймаг уриалга”-ыг хэрэгжүүлж, Аялал жуулчлал, амралтын газрууд хог хаягдлыг багасгах төлөвлөгөө гарган сумын ЗДТГ-аар батлуулан ажиллах | Жилдээ | ААНБ | СЗДТГ | Үйл ажиллагаа агаар | Төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна. | Хариуцлагын тогтолцоог сайжруулж, хамтран ажиллана. |
| | | 3.3.2.Амралт, аялал жуулчлалын газрууд хог хаягдлаа түр хадгалах цэг байгуулж, дахин ашиглах хог хаягдлыг ангилах ялгах ажлыг хэвшүүлэх | Жилдээ | ААНБ | СЗДТГ | Үйл ажиллагаа агаар | Чанартай сайн зохион байгуулж, хийсэн ажлын мэдээг тайланд тусгана. | Орчны бохирдол багасна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.3.3.Ангилсан хог хаягдлыг сумын төвийн ангилсан хог хаягдлыг хүлээн авах цэгт хүргэх | Жилдээ | ААНБ | СЗДТГ | Үйл ажиллагаагаар | | Байгальд хаягдах хог хаягдал багасна. |
| | | 3.3.4.Аялал жуулчлал, амралтын газрууд "Ирлээ, явлаа-Цэвэр" аян өрнүүлж, аялагч амрагчдад зориулсан сурталчилгааг хийх | Жилдээ | ААНБ | СЗДТГ | Үйл ажиллагаагаар | | Аялагч, амрагч нарт хог хаягдлын талаар зөв дадал хэвшил эзэмшүүлнэ. |
| | | 3.3.5.Аялал жуулчлал дагасан хог хаягдлын судалгааг гаргаж, цэвэрлэгээний ажлыг аяллын улиралд 3 удаа зохион байгуулах | V/20-V/25<br>VII/20-25<br>IX/20-25 | СЗДТГ, БААЖХ | ААНБ, иргэд | ОНТ, Хувийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр | | Аялал жуулчлал дагасан хог хаягдлыг цэвэрлэж, рашаан, голын голдирол болон байгальд хаясан хог хаягдал багасч орчны бохирдол доройтол буурна. |
| | | 3.2.6.Хог хаягдлаа тогтсон хугацаанд тээвэрлэх ажлыг хэвшүүлэх | 7-10 хоног тутам | ААНБ | СЗДТГ | Үйл ажиллагаагаар | | Орчны бохирдол доройтол багасна. |
| | | 3.2.7. Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийн үеэр хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажлыг зохион байгуулах | Тухай бүр | Зохион байгуулсан сумын ЗДТГ | БОАЖГ | ОНТ | | Үүссэн хог хаягдлыг цэвэрлэн зайлуулсан байна. |
| | | 3.2.8. Аялал жуулчлалын эвент арга хэмжээ болон бусад арга хэмжээ зохион байгуулахдаа талбайгаас 500 метрээс доошгүй зайд автомашины зогсоолын талбай, хог хаягдлын цэг, байгаль орчинд ээлтэй ариун цэврийн байгууламжийг байрлуулж тэмдэгжүүлэх | Тухай бүр | АЗДТГ, СЗДТГ | БОАЖГ, Булган сумын ТҮА, ААНБ | ОНТ | | Орчны бохирдол, доройтлыг багасгана. |
| 3.4 | Аюултай хог хаягдлын талаар | 3.4.1.Сумандаа байгаа Аюултай хог хаягдал, аюултай хог хаягдал үүсгэгчийн судалгааг гарган бүртгэлжүүлж, 06-р сарын 25-ны өдрийн дотор судалгааг БОАЖГ-т ирүүлэх | I-II улирал | СЗДТГ | ААНБ | Үйл ажиллагаагаар | Хугацаанд нь үнэн зөв гаргаж ирүүлнэ. | Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэл мэдээллийн сантай болно. |
| | | 3.4.2.Сумын БОХУБ, байгаль хамгаалагчид аюултай хог хаягдлын талаар иргэдэд сургалт, мэдээлэл хийх | I-II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | ААНБ, иргэд | Үйл ажиллагаа гаар | Хийсэн ажлын мэдээг 7 хоногийн мэдээнд ирүүлсэн байна. | Иргэдэд аюултай хог хаягдлын талаар тодорхой мэдээлэл өгсөн байна. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5 | "Жорлонгоо өөрчилье" аян, нүхэн жорлонг ариутган халдваргүйжүүлэх | 3.5.1. Сумын Засаг дарга нарт сумандаа үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААНБ-ын жорлонгийн судалгаа гаргаж, буулгах шаардлагатай жорлонгуудыг буулгаж, байгальд ээлтэй жорлон болгох, хийсэн ажлын тайлан мэдээг 07-р сарын 05-ны дотор ирүүлэх албан бичиг хүргүүлэх | 3.5.1.1. Төр төсвийн байгууллагуудын ААНБ-ын нүхэн жорлонг байгальд ээлтэй боловсон жорлон болгох | I-II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | ААНБ, иргэд | ОНТ, ААНБ-ын хөрөнгө | Жорлонгийн тоо | Нүхэн жорлонг буулгаж, хөрс, ус, орчны бохирдлыг багасгана. |
| | | | 3.5.1.2. Аялал жуулчлал, рашаан, амралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын нүхэн жорлонг байгальд ээлтэй боловсон жорлон болгох | I-II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | ААНБ, иргэд | ААНБ-ын өөрийн хөрөнгө | Жорлонгоо өөрчилсөн иргэн, ААН-ын тоо | Амрагч, аялагчдын тав тухыг хангаж, нүхэн жорлонг буулгаж, хөрс, ус, орчны бохирдлыг багасгана. |
| | | | 3.5.1.3.ШТС-уудын нүхэн жорлонг байгальд ээлтэй боловсон жорлон болгох | I-II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | ААНБ | ААНБ өөрийн хөрөнгөөр | | Хөрс, ус, орчны бохирдол багасна. |
| | | | 3.5.1.4.Худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, ААНБ-ын нүхэн жорлонг байгальд ээлтэй боловсон жорлон болгох | I-II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | ААНБ,иргэн | Иргэн, ААНБ өөрийн хөрөнгөөр | | Орчны бохирдол буурч, эрүүл аюулгүй орчин бүрдэнэ. |
| | | | 3.5.1.5. Гол, булаг шанд, рашаан усан сан бүхий газрын нүхэн жорлонг буулгаж, байгальд ээлтэй боловсон жорлон болгох ажлыг зохион байгуулах | II улирал | СЗДТГ, БОХУБ, байгаль хамгаалагч | Багийн Засаг дарга | Иргэн, ААНБ өөрийн хөрөнгөөр | Буулгаж, өөрчилсөн жорлонгийн тоо | Орчны бохирдол буурч, эрүүл аюулгүй орчин бүрдэнэ. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.5.2.Сум бүр айл өрх, албан байгууллагын нүхэн жорлонг ариутган халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах | II улирал | СЗДТГ, ЭМТ | Багийн Засаг дарга, айл өрх | Үйл ажиллага агаар | Хамрагдсан айл өрхийн тоо | Орчны бохирдол буурч, эргүүл аюулгүй орчин бүрдэнэ. |
| 3.6 | Сумдад хог ачих автомашин нийлүүлэх | 3.6.1.Хог ачих зориулалтын тоноглогдсон авто машиныг 6 суманд нийлүүлнэ. | I-VI сар | БОАЖГ | ААНБ | ОНТ | Техникийн тодорхойлолтонд заагдсны дагуу нийлүүлнэ | Булган, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Могод, Бугат, Дашинчилэн сум хог ачих автомашинтай болно. |
| | | 3.6.2.Хог хаягдал тээвэрлэх автомашиныг 9 суманд нийлүүлнэ. | I-VI сар | БОАЖГ | ААНБ | ОНТ | Техникийн тодорхойлолтонд заагдсны дагуу нийлүүлнэ | Баян-Агт, Гурванбулаг, Тэшиг сум, Хялганат тосгон, Баяннуур, Орхон, Сайхан,Сэлэнгэ, Булган хог ачих автомашинтай болно. |
| **4. Хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх** | | | | | | | | |
| 4.1 | Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах | 4.1.1.Сум бүр хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах | I-IV улирал | СЗДТГ | Багийн Засаг дарга | ОНТ | 1-ээс доошгүй иргэнийг олон нийтийн байцаагчаар ажиллуулсан байна. | Монголд зочлох жилийн хүрээнд аялагч, жуулчдад хог хаягдлын талаар мэдээлэл сурталчилгаа хийж, хяналт тавин ажиллана. |
| 4.2 | Хяналт шалгалт хиййх | 4.2.1. Аялал жуулчлал, амралтын газруудын Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх | VI/05-VIII/05 | БОАЖГ | СЗДТГ | ОНТ | Илэрч, арилгуулсан зөрчлийн тоо | Хог хаягдлы тухай хуулийн хэрэгжилтийг хангуулна. |
| | | 4.2.2 Уул уурхайн ААНБ-уудын Хог хаягдлын хуулийн хэрэгжилттэй танилцаж, хяналт шалгалт хийх, Хог хаягдлын хуулийн талаар сургалт зохион байгуулах, сурталчлах | V/01-VI/30 | БОАЖГ СЗДТГ | ААНБ | ОНТ | Уул уурхайн бүх ААНБ-ыг хамруулна. | Хууль бус хогийн цэгийн тоог бууруулж, ААНБ-уудад хуулийг сурталчилна. |
| | | 4.2.3.Автозасвар, тос тосолгооны төв, автомашины угаалгын газар, хүнсний болон барааны зах, худалдааны төв, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд | III/15-X/15 | БОАЖГ | СЗДТГ | ОНТ | Илэрч, арилгуулсан зөрчлийн тоо | Хуулийн хэрэгжилтийг хангуулна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгаль орчныг хамгаалах, эрүүл ахуй ариун цэврийн шаардлагуудыг хангуулах, ариун цэврийн байгууламжуудыг стандартад нийцүүлэх, холбогдох хууль тогтоож, стандартын хэрэгжилтэд тогтмол хяналт шалгалт зохион байгуулах | | | | | | |
| | | 4.2.4.Хөдөөний малчин айл өрхийг нүүхдээ буйраа цэвэрлэж, хог хаягдлыг зориулалтын цэгт хаясан байдалд хяналт тавих | II-III улирал | СЗДТГ | Багийн Засаг дарга, БОХУБ | ОНТ | Илэрч, арилгуулсан зөрчлийн тоо | Хуулийн хэрэгжилтийг хангуулна. |

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 06-ны өдрийн А/128 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

## ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН" АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

| Д/д | Үйл ажиллагаа | Тоо хэмжээ | Зардал (Төг) | Төсөв (Төг) |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг зохион байгуулах (16 сум 1 тосгон) | 17 | 1 770 000 | 30 090 000 |
| 2 | "Монголд зочлох жил", аяны хүрээнд аймгийн хэмжээнд орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөг танилцуулж, аяныг сурталчилж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалт, сурталчилгааг зохион байгуулах /төрийн албан хаагчид, ААНБ-ын дарга, багийн Засаг дарга, иргэдийг хамруулна/ | 16 сум, 1 тосгон | Шатахуун, томилолт, бусад зардал | 3 861 000 |
| **Нийт** | | | | **33 951 000** |

Сургалт, сурталчилгаа, мэргэжил арга зүйн зөвлөгөө
өгөх зардлын задаргаа

| д/д | Зардлын төрөл | Хугацаа | Хэмжих нэгж | Нэгжийн зардал/төг/ | Тоо хэмжээ | Нийт /төг/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Томилолтын зардал | V/01-VII/01 | Хүн/ хоног | 44000 | 4/16 | 2 816 000 |
| 2 | Шатахууны зардал /ДТ/ | | 17л/100км | 3910 | 280 | 1 045 000 |
| Дүн | | | | | | 3 861 000 |

Сургалт, сурталчилгаа, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын маршрут,
шатахууны тооцоо

| д/д | Сумын нэр | Зай /км/ | Д-түлш-Норм /л/ | Шатахууны хэмжээ /л/ | Нэгжийн үнэ төг | Бүгд үнэ /төг/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Булган -Орхон | 22 | 17 | 3.74 | 3910 | |
| 2 | Орхон -Бүрэгхангай | 54 | 17 | 9.18 | 3910 | |
| 3 | Бүрэгхангай-Баяннуур | 100 | 17 | 17 | 3910 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Баяннуур-Дашинчилэн | 30 | 17 | 5.1 | 3910 | |
| 5 | Дашинчилэн-Рашаант | 70 | 17 | 11.9 | 3910 | |
| 6 | Рашаант-Гурванбулаг | 80 | 17 | 13.6 | 3910 | |
| 7 | Гурванбулаг-Могод | 108 | 17 | 18.36 | 3910 | |
| 8 | Могод -Хишиг-Өндөр | 90 | 17 | 15.3 | 3910 | |
| 9 | Хишиг-Өндөр-Булган | 68 | 17 | 11.56 | 3910 | |
| | **Дүн** | **622** | | **105.74** | 3910 | **413,443.4** |
| 10 | Булган -Сайхан | 101 | 17 | 17.17 | 3910 | |
| 11 | Сайхан-Баян-Агт | 72 | 17 | 12.24 | 3910 | |
| 12 | Баян-Агт-Хутаг-Өндөр | 80 | 17 | 13.6 | 3910 | |
| 13 | Хутаг-Өндөр-Тэшиг | 103 | 17 | 17.51 | 3910 | |
| 14 | Тэшиг-Булган | 246 | 17 | 41.82 | 3910 | |
| | **Дүн** | **602** | | **102.34** | 3910 | **400,149.4** |
| 15 | Булган-Бугат | 52 | 17 | 8.84 | 3910 | |
| 16 | Бугат-Сэлэнгэ | 101 | 17 | 17.17 | 3910 | |
| 17 | Сэлэнгэ-Хялганат | 40 | 17 | 6.8 | 3910 | |
| 18 | Хялганат-Хангал | 40 | 17 | 6.8 | 3910 | |
| 19 | Хангал-Булган | 113 | 17 | 19.21 | 3910 | |
| | **Дүн** | **346** | | **58.82** | 3910 | **229,986.2** |
| | **Нийт** | **1647** | | **266.9** | 3910 | **1,043,579.0** |